

**З.Т.Голенкова***ОХУ-ын ШУА-ийн Социологийн Хүрээлэнгийн орлогч захирал. Доктор (Sc.D), профессор***Е.Д.Игитханян***ОХУ-ын ШУА-ийн Социологийн Хүрээлэнгийн ЭШТА. Доктор (Ph.D), профессор***(Орч) Т.Бүрэнжаргал***МУИС-ийн НШУС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш.**Доктор (Ph.D), дэд профессор*

## АЖИЛЧДЫН НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН ЧАДАВХ: СОЦИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ<sup>1</sup>

*Abstract:* The article analyzes the formation of the main basic social status characteristics of the workers. Also author considered workers life strategies and orientations social environment and adaptation in labor market, family life and social activities.

*Key words:* social and political potential of workers, employment, labor market, social structure, social institutions

Сүүлийн арав гаруй жилд ОХУ-д болж буй өөрчлөлтүүд нь нийгмийн бүтцийг үлэмж өөрчилсөн. Нийгмийн ялгарлын үр дүнд шинэ бүлгүүд бий болж, нийгмийн мобил хөдөлгөөний чиг хандлагад эрс өөрчлөлтүүд гарахын зэрэгцээ нийгэмд төвөгтэй шинэ голомтууд үүсч, хүмүүсийн үнэт зүйлийн баримжаа, зан үйлийн загвар өөрчлөгдөж байна. Эдгээр нь эдийн засгийн өөрчлөлтүүдээс эхэлсэн бөгөөд улсын өмчтэй эдийн засгийн тогтолцооноос төрийн, хувийн, орон нутгийн, холимог өмч зэрэг олон хэлбэртэй өмч бүхий эдийн засагт шилжсэн юм. 2010 оны эцсээр нийт ажиллагсдын 58,4 хувь хувийн хэвшлийн салбарт, 30 хувь төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад, 0,5 хувь олон нийтийн болон шашны байгууллагад, 5,5 хувь холимог өмчит байгууллагад, 4.7 хувь гадаадын хамтарсан байгууллагад (1) ажиллаж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү олон өмчийн хэлбэр нь ангийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын харилцааны шинэ нөхцөл байдлыг бий болгож, нийгмийн анги, бүлэг, давхрааны үүрэг ролийн динамик үйл явцыг өөрчилж, түүний бүтээгч үүргийг сэргээхийн зэрэгцээ автономит байр суурийг тодорхой болгосон юм. Юуны өмнө, макро түвшинд өнөөгийн нийгмийн үндсэн бүлгүүдийн үүсэл төлөвшлийг аваад үзвэл өмчтөн болон хөлсний ажилтнуудын тухай ярьж болох юм. Хөдөлмөр эрхэлж буй хүн амын 6,5 хувь нь өмчтөн бол хөлсний ажилтнууд 93,5 хувийг эзэлж байна.(2) Хөлсний ажилтнууд нийгмийн макро бүтцийн бүрэлдэхүүн хэсэг болохынхоо хувьд нийгмийн ялгарлын үйл явцтай шууд холбоотой. Энэхүү ялгарлын түвшин болон хэлбэр олон янз байдаг. Тэдний эдийн засгийн (улсын болон хувийн хэвшлийн) салбарт ажиллаж буй байдал, засаглал эрх мэдэл, ажил мэргэжил, улс төр болон соёлын харилцаа холбооны тогтолцоонд эзлэж буй байр суурьнаас хамааралтай байдаг. Ийнхүү энэ байдлыг суурь үзэл баримтлалаа болгож үзэх юм бол нийгмийн статус нь бидний судлах зүйл болж нийгмийн дэд нийтлэг, бүлэг, давхраа болж байна. Хөлсний ажилтнуудын энэхүү том бүлэгт ажилчдыг багтааж авч үзэж болох юм. Янз бүрийн түүхэн цаг үед “ажилчин”, “ажилчин анги” хэмээх ойлголтыг эрдэмтэн судлаачид янз бүрээр авч үздэг байжээ. Зөвлөлт Оросын үед ажилчин анги нь хөдөлмөр эрхэлж буй хүн амын 70 хувийг эзэлж байсан томоохон бүлэг хийгээд нийгэм эдийн засгийн хөгжлийн хүчтэй хөдөлгөгч хүч болж байсан юм.

ЗХУ-д ажилчин ангийн дотоод ялгарал байсан нь түүний хөгжил төлөвшлийн нэгэн чухал шинж бөгөөд нийгэм эдийн засгийн нарийн төвөгтэй тогтолцоо оршиж байсныг илэрхийлж байна. Пост зөвлөлт орны зах зээлийн нөхцөл байдалд ажилчин анги нь өөрчлөгдөж байна. 1980-аад онд энэ асуудлын талаар их ярьдаг байсан бөгөөд зарим эрдэмтэн судлаачид ажилчдыг бага, дунд, өндөр мэргэшил шаардсан хөдөлмөр эрхэлдэг бүлэг гэж үзсэн бол зарим

<sup>1</sup> Өгүүлэл нь ОХУ-ын Шинжлэх ухааны сангийн № 11-03-00231-а санхүүгийн тэтгэлгээр бэлтгэгдсэн.

## Уул уурхай, байгаль хамгааллын социологи

нь үзэхдээ ажилчид “аж үйлдвэржилтээс өмнөх”, “аж үйлдвэржилтийн эхний үеийн”, “шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн үеийн” хөдөлмөр эрхэлдэг бүлэг хэмээжээ.

Ийнхүү зөвлөлтийн үед ажилчин анги нь зөвхөн нийгмийн бүтцийн нэгэн ойлголт бус харин хөдөлмөр эрхэлж буй хүн амын гуравны нэгийг эзлэж байсан нийгмийн томоохон нийтлэг болохын зэрэгцээ нийгэм эдийн засгийн хөгжлийн чухал хүч болж байсан хэмээн дүгнэж болох юм. Ажилчин ангийг үйлдвэрлэлийн бодит нөөц хүчийг бүрэлдүүлдэг бааз бүхий нийгмийн бүлэг хэмээн тодорхойлж болно. Тухайн үед янз бүрийн түвшний мэргэшил бүхий ажилчдыг бэлтгэдэг нөхөн үйлдвэрлэлийн тогтолцоо үйлчилж байжээ.

2010 оны эцэст ажилчид нийгмийн бүтцэд 40,3 хувийг эзэлж байна. Харин энэхүү үзүүлэлт 2001 онд 58,2 хувь, 2003 онд 46,9 хувь, 2008 онд 41,7 хувийг эзэлж байсан аж. (Хүснэгт 1)

**Хүснэгт 1. Хөдөлмөр эрхэлж буй хүн амын дунд ажилчдын эзлэх хувийн өөрчлөлт (хувиар)**

Эдийн засгийн үйл ажиллагааны төрөл ба мэргэшлийн түвшин	2001	2003	2007	2010
Хөдөө аж ахуй, ой, ан агнуурын мэргэшилтэй ажилчид	5.6	4.8	3.5	3.0
Жижиг болон том аж ахуйн нэгж, урлаг соёл, барилга, холбоо, уул уурхайн мэргэшилтэй ажилчид	24.0	16.0	14.9	13.9
Оператор, слесарь, машин тоног төхөөрөмжийн угсралтын ажилчид	14.0	13.9	12.0	12.5
Мэргэшилгүй ажилчид	14.6	12.2	11.3	10.9

Эх сурвалж: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Москва, 2003, 98-99 тал; Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Москва, 2003, 100-101 тал; ОХУ-ын статистикийн жил тутмын эмхтгэл. Москва, 2011, 124 тал;

Эдийн засгийн бүхий л салбарт ажиллаж буй мэргэшилтэй болон мэргэшилгүй ажилчдын тоо аажмаар буурч байгааг хүснэгтээс харж болно. Үйлдвэрлэлийн уналт нь **ажилгүйчүүдийн давхрааг** бий болгоход хүргэж байна. ОХУ-д 2010 оны эцэст ажилгүйдлийн түвшин 8 хувь байсан бол эдийн засгийн идэвхтэй хүн амын дунд эдгээр хүмүүсийн дундаж нас 34,9 байна.<sup>1</sup>

**Хүснэгт 2. Ажилчдын дундах ажилгүйдлийн түвшний өөрчлөлт (хувиар)**

Эдийн засгийн үйл ажиллагааны төрөл ба мэргэшлийн түвшин	2003	2007	2009
Хөдөө аж ахуй, ой, ан агнуурын мэргэшилтэй ажилчид	4,6	5,1	2,7
Жижиг болон том аж ахуйн нэгж, урлаг соёл, барилга, холбоо, уул уурхайн мэргэшилтэй ажилчид	8,5	4,9	15,2
Оператор, слесарь, машин тоног төхөөрөмжийн угсралтын ажилчид	7,6	4,3	10,6
Мэргэшилгүй ажилчид	10,3	8,1	16,4

Эх сурвалж: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Москва, 2003, 263 тал; мөн тэнд. Москва, 2007, 213 тал; мөн тэнд. Москва, 2009, 4.46 хүснэгт

Аж үйлдвэрийн салбарт мэргэшсэн ажилчдын ажилгүйчүүдийн дунд эзлэх хувийн жин өндөр байгаа бөгөөд 2007-2009 онуудад тэдний тоо бараг 1,8 дахин өссөн байна. Энэ нь улс орны эдийн засгийн нөхцөл байдал муудсан бодит үр дагавартай шууд холбоотой. Хямралын үед үйлдвэр аж ахуйн газрууд ашиг орлогоо бүрэн гүйцэд авч чадаагүйгээс хамаараад ажиллах хүчээ цомхтголд оруулж, ялангуяа 2008-2009 онуудад энэ нөхцөл байдал илүү өргөн хүрээг хамарсан юм. Энд ажилгүй болсон мэргэшсэн ажилчдын тухай яригдаж байгаа бөгөөд өнөөгийн Оросын нийгмийн амьдралын өөрчлөлтийн үйл явцтай уялдан ажилчдын нөхцөл байдал шинэчлэгдэж болох байлаа. Өнөөгийн хөдөлмөрийн харилцаанд энэхүү бүлгийн зан үйлийн сэдэл, амьдралын нөхцөл, амьжиргааны түвшинг өөрчлөөд зогсохгүй зах зээлийн нөхцөлд дасан зохицох боломжийг ялангуяа нийгмийн “зүтгүүрийн” үүргийг бууруулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд гарч буй өөрчлөлтүүд нь хагас өдрийн, түр зуурын, хоёрдогч, давхар хөдөлмөр эрхлэлт зэрэг **шинэ хэлбэрүүдийг** бий болгож байна. Өнөөгийн

<sup>1</sup> ОХУ-ын статистикийн жил тутмын эмхтгэл. Москва, 2011, 118 тал. Холбооны статистикийн алба.

Оросын мэргэжлийн давхраажилд *давхар ажил эрхлэх* явдал чухал байр суурь эзэлж байгаад анхаарал хандуулан авч үзье. Давхар хөдөлмөр эрхлэлт нь сүүлийн арваад жилд өргөн тархсаныг ОХУ-ын статистикийн тоо баримтууд гэрчилж байна. Давхар хөдөлмөр эрхлэхэд янз бүрийн хориг саад байхгүй болсны үр дүнд энэ хэлбэрийн хөдөлмөр эрхлэх бодит боломж бүрдсэн юм. Үүнээс гадна эдийн засгийн хямралын үеийн хүмүүсийн амьдралын хүнд нөхцөл байдал нь нийгмийн олон бүлгийн төлөөллүүдэд давхар хөдөлмөр эрхлэх сэдлийг бий болгосон байна. Энэ нь ажил олгогч болон хөлсний ажилтнуудад ч, материаллаг болон материаллаг бус үйлдвэрлэлийн салбарынханд ч хамааралтай юм. 2009 оны эцсээр давхар хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн тоо үндсэн ажлаа хийж буй ажилтнуудын дунд 2064,0 мянган хүн байна.<sup>1</sup> Хөдөлмөр эрхлэлтийн энэхүү тогтолцоонд ажилчид ямар байр суурь эзэлж байна вэ?

### Хүснэгт 3. Давхар хөдөлмөр эрхэлж буй ажилчдын тооны өөрчлөлт (хувьар)

Эдийн засгийн үйл ажиллагааны төрөл ба мэргэшлийн түвшин	2003	2007	2010
Хөдөө аж ахуй, ой, ан агнуурын мэргэшилтэй ажилчид	60.8	53.2	49.0
Жижиг болон том аж ахуйн нэгж, урлаг соёл, барилга, холбоо, уул уурхайн мэргэшилтэй ажилчид	1.8	0.1	2.1
Оператор, слесарь, машин тоног төхөөрөмжийн угсралтын ажилчид	1.2	0.2	1.4
Мэргэшилгүй ажилчид	2.2	2.0	2.6

Эх сурвалж: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Москва, 2003, 116 тал; мөн тэнд. Москва, 2007. 96, 114 тал; мөн тэнд. Москва, 2009, 41 тал.

Давхар хөдөлмөр эрхлэх нь нийгмийн бараг бүхий л бүлэг давхрааг хамарсан нийгмийн дасан зохицлын чухал арга хэрэгсэл байсныг тэмдэглэх хэрэгтэй. Ажилчид энэхүү харилцаанаас ангид байгаагүй гэхдээ эдийн засгийн үйл ажиллагааны төрлөөс хамаараад ямар төрлийн хөдөлмөрийг давхар эрхлэж байгаа нь харилцан адилгүй юм. Хөдөө аж ахуй болон ойн аж ахуйд ажилладаг ажилчид давхар ажил хийхдээ илүү идэвхтэй байсан бол аж үйлдвэрийн ажилчид харьцангуй бага байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн бүхий л салбарт ажиллаж буй мэргэшилгүй ажилчдын давхар хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдалд харагдахуйц өөрчлөлт гараагүй байна.

Нийгмийн шинэчлэлийн жилүүдэд ажилчдын нөхцөл байдал үлэмж өөрчлөгдсөн. 1980-аад оны сүүлээр судлаачид тэмдэглэхдээ “ажилчид уруудах мобил хөдөлгөөнд өртсөн нийгмийн бүлэг болж байна” гэжээ.<sup>(4)</sup> Сүүлийн арваад жил ажилчдыг нийгмийн бүлэг болохын хувьд судалгаа шинжилгээний эрэл хайгуулын гадуур үлдээж байсан нь тухайн үед “дунд анги”, “бизнес эрхлэгчид”, “дээд анги”, “ажилгүйчүүд” зэрэг нийгмийн бүлгүүдийг илүү сонирхон судалж байсантай холбоотой. Гэвч пост Орост ажилчид алга болоогүй, мөн хөдөлмөр эрхлэж буй хүн амын дунд “живээгүй” юм. Тэд хөлсний хөдөлмөр эрхлэгчдийн дунд чухал байр суурь эзэлдэг бөгөөд нийгэм эдийн засгийн харилцаанд амжилттай оролцоход тэдний хүчин чадал нөөцөөс ихээхэн хамаарна. Ажилчдын нийгмийн мөн чанар юунд орших вэ? Хөдөлмөр эрхэлж буй хүн амын дунд ажилчид 40,4 хувийг эзэлж байгаа нь статистикийн ерөнхий үзүүлэлт юм. Гэхдээ бидний судалж буй субъектийн хөгжлийг улс төр, соёлын өөрчлөлтийн урсгалд татан оролцуулах талаар авч үзэх ёстой.

Энэхүү өгүүллийн судлах зүйл бол нэг талаас ажилчдын нийгэм-эдийн засагт эзлэх байр суурийн төлөвшил, нөгөө талаас тэдний амьдралын баримжаа, чадвар чадавхи болон нийгмийн орон зайд дасан зохицох асуудлыг авч үзэх явдал юм.

Пост Орос улсад нийгмийн тогтолцоо болон нийгмийн институци эрс өөрчлөгдсөнтэй холбогдон ажилчдын нийгэм улс төрийн чадавх чадамжийг төлөвшүүлэхэд ач холбогдол бүхий судалгааны дараах үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон. Үүнд:

- Ажилчдын мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн үнэ цэнийг шинжлэн судлах,
- Ардчиллын үнэт зүйлийн тогтолцооны төлөвшлийн үйл явцад ажилчдын оролцооны түвшинг тодорхойлж, ялангуяа “нийгмийн шударга ёс”, “нийгмийн тэгш эрх”, “эрх чөлөө” зэрэг ойлголттой ажилчдын нөхцөл байдал хэрхэн уялдаж байгааг судлах,
- Ажилчдын үнэт зүйлийн баримжаалыг тухайлбал материаллаг байдал, өнөөдрийн болон маргаашийн амьдралдаа итгэх итгэл зэрэг асуудлыг өргөн хүрээнд нь шинжлэх,

<sup>1</sup> Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа. Москва, 2009, 2.57 хүснэгт

- Ажилчдын нийгмийн мобил хөдөлгөөний онцлогийг авч үзэхийн зэрэгцээ тэдний нийгмийн байр суурь болон оршин амьдрах газраа өөрчлөхөд хэр зэрэг бэлтгэлтэй байгаа эсэхийг судлах

ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх РАГС Социологийн төвөөс 2011 оны 4-р сард явуулсан “Оросын нийгэм дэх түүхэн дурсамж: төлөвшлийн нөхцөл байдал ба асуудлууд” судалгааны тоо баримтууд нь энэхүү өгүүллийн мэдээллийн бааз боллоо.<sup>1</sup>

Аж үйлдвэрийн, барилгын, тээврийн салбарт ажиллаж буй нийт 256 респондент судлагдсан юм. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 46,3 хувь нь 18-39 насны залуучууд, 46,8 хувь нь 40-59 насны дунд үеийнхэн, 6,9 хувь нь 60-с дээш насны ахмад үеийнхэн байна. Эдгээр ажилчдын бүлгийн боловсролын түвшинг аваад үзвэл 16,2 хувь нь дээд эсвэл бүрэн бус дээд, 44,2 хувь нь тусгай дунд, 32,5 хувь нь бүрэн дунд, 7.2 хувь нь бүрэн бус дунд эсвэл бага боловсролтой хүмүүс байна. Ийнхүү тэд хөлсний хөдөлмөр эрхэлдэг, хөдөлмөр эрхлэх насны, мэргэжил боловсролын болон соёлын хувьд өндөр түвшинд байгаа хүмүүс ажээ.

Юуны өмнө, ажилчдын нийгмийн байр сууринд шууд нөлөөлж буй хөдөлмөрийн харилцааны өөрчлөлтийн үзүүлэлтүүдийг авч үзье. Хөдөлмөрийн харилцаанд тодорхой тогтсон хандлагууд бий болж байна. Судалгаанд хамрагдсан ажилчдын хувьд ажил хөдөлмөр нь тэдний амьдралд чухам ямар ач холбогдолтой талаарх санал бодлыг авч үзсэн юм. Тэд хариулахдаа 79,8 хувь нь ажлын цалин хөлсний хэмжээ, 49,1 хувь нь сонирхолтой ажил, 26 хувь нь хамт олонтой байх боломжтой, 25,6 хувь нь нийгэмд тустай ажил, 19 хувь нь нийгэмд тодорхой байр суурь эзлэх боломжтой хэмээжээ. Ийнхүү ажлыг оршин амьдрах эх сурвалж болохынх нь хувьд материаллаг үнэт зүйлийн үүднээс үнэлэн дүгнэсэн нь бусад хариултын хувилбараас илүү өндөр хувьтай байсныг тэмдэглэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, материаллаг нөөцийг чухалчлан үзсэн нь давамгайлж байлаа. Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар хөдөлмөр бол мэргэжлийн мэдлэг чадвар, бие бялдрын хүчин чадлын болон оюун сэтгэхүйн зарцуулалтын үйл явц байдаг учраас тодорхой хэмжээний материаллаг нөхөн төлбөрийг шаардаж байдаг хэмээжээ. Мөн тэдний хувьд хөдөлмөрийн агуулга буюу мэргэжлийн нөөц маш чухал байдаг аж. Түүнчлэн судалгаанд оролцсон хүмүүсийн хувьд нийгмийн харилцаа холбоо буюу хамт олонтой байх явдлыг ач холбогдолтойд тооцож байна. Ажилтай байх нь албан харилцааг хүмүүсийн хоорондын албан бус харилцаатай хослуулах, ижил мэргэжил боловсролтой болон ижил үзэл бодол хүсэл сонирхолтой хүмүүстэй харилцаа холбоо тогтоох боломжтой гэж үзжээ. Нийгмийн тодорхой хүрээлэлд орж харилцаа холбоо тогтоох нь чухал хэмээн ажилчдын 26 хувь нь үзсэн бол нийгэмд тодорхой байр суурь эзлэх болон нийгэмд ач тустай байх боломжийг ажил хөдөлмөр олгодог гэж 45 хувь нь үзлээ.

Тиймээс хөдөлмөрт хандах хандлагыг өргөн утгаар ойлгосноор ажилчдын ажил эрхлэлтийн мөн чанарыг мэдэх юм. Ажилчид нь хөдөлмөрийн харилцааны нэгэн хэсэг болохынхоо хувьд бүхэлдээ биеэ даасан субъект юм. Нийгмийн орчинд бие хүний хөгжил төлөвшлийг хангаж байдаг хөдөлмөрийн нэгэн чухал шинж бол оршин тогтнох материаллаг нөхцөлийг бүрдүүлдэг. Зах зээлийн эдийн засгийн хөгжлийн явцад үр ашигтай хөдөлмөр эрхлэлтийг хөгжүүлэх, ажлын байрны төлөө зохистой өрсөлдөөнтэй байх, ажиллах хүчний өсөлтийг тооцох, бие хүний мэргэжлийн, сэтгэлгээний болон боловсон хүчний нөөцийг зүй зохистой ашиглах нь чухал болж байна.

Ажилчдаас тэдний амьдралын үнэт зүйлийн талаар тандахаар арван үнэт зүйлийг санал болгоход мөнгө олох арга ухаан, мэргэжлийн чадвар, хамт олонч чанар буюу ажил дээрх харилцан туслалцаа гэсэн шинжүүд эхний гурван байранд оржээ. Судалгаанд оролцогчид ажил хөдөлмөр, мэргэжлийн чадварыг эрхэмлэн амьдралынхаа үнэт зүйлтэй холбон ойлгож байна. Өөрчлөгдөж буй нийгэм эдийн засгийн бодит нөхцөл байдалд дасан зохицох гол хэрэгсэл бол цалин хөлс бөгөөд үүгээр дамжин хөдөлмөрт хандах хандлага тодорхойлогдож болох юм. “Та өөрийнхөө материаллаг байдлаа хэрхэн үнэлж байна вэ?” гэсэн асуултанд зөвхөн 0,8 хувь нь материаллаг хүндрэл бэрхшээл байхгүй гэсэн бол 15,1 хувь нь материаллаг байдал сайн гэхдээ зарим зүйлийг авч чаддаггүй гэсэн нь ажилчдын хувьд харьцангуй хангамж сайтай хэсэг нь болж байна. Түүнчлэн 66,4 хувь нь хоол хүнс, хувцас хунараа л авч чаддаг гэж хариулсан дундаж материаллаг хангамжтай ажилчид байхад 12,5 хувь нь хоол хүнс, хувцас хунарт мөнгө хүрэлцдэггүй ядуу амьдралтай, 2,3 хувь нь нэн ядуу амьдарч буй ажилчид байна. Ийнхүү чинээлэг, дундаж, ядуу байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээрх өрсөлдөх чадвар доогуур

<sup>1</sup> Судалгааг ОХУ-ын бүхий л эдийн засаг-газар зүйн бүс мужийг хамарсан 21 газрыг хамруулан авсан. Олон шатат түүврийн аргыг хэрэглэн 1600 хүний хамруулжээ.

байгаагийн илэрхийлэл юм. “Өнөөдөр Таны амьдрал ямар байна вэ?” гэсэн асуултанд 65 хувь нь сайн эсвэл гайгүй хэмээн хариулсан нь сайхан амьдрах гол хүчин зүйлийг ажил хөдөлмөртэй холбон ойлгож байна.

XX зууны 90-ээд онд нийгмийн тэгш бус байдлын янз бүрийн хэлбэрүүд бий болсон. Энэхүү тэгш бус байдал нь хүний амьдралын бүхий л хүрээг тухайлбал нийгмийн, эдийн засгийн, улс төрийн болон бусад хүрээг хамарсан. Орлогын ялгарал, баян болон ядуу давхрааны үүсэл нь нийгмийн тэгш бус байдлын хамгийн тод илрэл юм. Өнөөгийн ОХУ-ын хамгийн баян давхрааныхны (10 хувь) орлого болон хүн амын хамгийн ядуу давхрааныхны орлогын харьцаа 1:30 байна. (6) Энэ нь барууны орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү их зөрүү байгаа юм.

Нийгмийн бүлэг давхрааныхны хооронд орлогын хэмжээний ялгаа их байгаа эсэхийг судалгаанд оролцогчдоос лавлахад 63 хувь нь хүлээн зөвшөөрсөн байна. Үүнээс гадна чанартай боловсрол олж авахад нийгмийн тэгш бус байдал их илэрч байна. Зөвлөлтийн үед материаллаг тэгш бус байдлаас үл хамааран ихэнх залуучууд дунд болон дээд мэргэжил боловсрол эзэмших боломжтой байв. Өөрөөр хэлбэл чинээлэг, дундаж, ядуу давхрааныхан боловсролтой болох боломжтой байлаа. Гэхдээ тухайн үед нийгмийн дээд давхрааныхны (элит) сурдаг их, дээд сургуулиуд байсан бөгөөд тэгш бус байдал нь элсэгчдийн эцэг эхийн нам төрийн албанд хашдаг албан тушаалаас хамаарахаас гадна элсэлтийн зарчим нь ч тэгш бус байв. Ерөнхийдөө үнэ төлбөргүй боловсролын тогтолцоо нь нийгмийн бүлэг давхрааныхныг тэгшитгэх, дунд болон дээд давхраанд шилжих боломжийг олгодог нийгмийн мобил хөдөлгөөнийг идэвхжүүлдэг.

Нийгмийн тэгш бус байдал тод илэрч байгаа хүрээ бол хуулийн хэрэгжилтийн шударга бус байдал буюу албан тушаалтан болон энгийн иргэд хуулийн өмнө тэгш бус байна гэж судалгаанд оролцогчдын 62 хувь үзсэн учраас тэдний 53 хувь нь төр засаг болон иргэдийн хоорондын харилцаа муу гэж үнэлжээ. Энд төр болон “би”-ийн харилцааны талаарх иргэний мэдрэмжийн тухай асуудал хөндөгдөж байна. Үндсэн хуулиараа ОХУ нь нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх ёстой боловч судалгаанд оролцогчдын 58,5 хувь нь төр үүргээ бараг хэрэгжүүлж чадахгүй байгаа гэж үзсэн бол 26 хувь нь эерэг үнэлсэн байна. Өнөөдөр ОХУ-д иргэний нийгэм хөгжиж чадаагүй, зөвхөн эхлэлийн үе шатандаа явж байгаа бөгөөд иргэний нийгмийн ихэнх элементүүдийг хааж боосоор байна. Өнөөгийн нээлттэй ардчилсан нийгэмд байх ёстой иргэний нийгмийн хөгжлийн түвшин, агуулга байхгүй байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь төрөлх эх орондоо аюулгүй амьдарч хамгаалагдаж чадахгүй байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ аливаа хүндрэл бэрхшээлтэй тулгарвал төрийн зүгээс дэмжлэг авч чадна гэж ердөө 18,1 хувь нь үзсэн бол төрийн оролцоогүй өөрөө асуудлаа шийдвэрлэдэг гэж 74 хувь нь үзжээ. Энэхүү тоо баримт нь иргэдэд төрийн зүгээс тавьдаг халамж хамгаалал байхгүйг харуулахын зэрэгцээ тэгшитгэх үзэл баримтлал үе өнгөрөөснийг илэрхийлж байна. Орчин үеийн нийгмийг хөгжүүлэх өөр парадигм гарч ирж байна. Өнөөдөр иргэний эрх чөлөөний мэдрэмжийг боогдуулж, иргэдийн эрх ашиг сонирхлыг харгалзан үздэггүйд зах зээлийн эдийн засгийн хууль дүрэм бус харин төрийн тогтолцооны бүхий л салаа мөчирт илэрч буй сөрөг нөлөөллүүд буруутай. Сүүлийн арваад жилд хэрэгжүүлсэн өөрчлөлтийг судалгаанд оролцогчдын 40 хувь нь үнэлэхдээ энэ үе бол эмгэнэл бэрхшээлийн үе байсан гэж үзжээ. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих Оросын нийгмийн өөрчлөлтийн суурь зарчмууд нь нийгэм-эдийн засгийн өөрчлөлтийн үнэт зүйлтэй уялдаж чадаагүй, ялангуяа хүн амын хөдөлмөр эрхлэх болон орлогоо нэмэгдүүлэх боломжийг хангаагүй, мөн эмзэг бүлгийн хүмүүсийн нийгмийн халамжийг дээшлүүлж чадаагүй юм. Хөдөлмөрийн зах зээл маш нарийн төвөгтэй эдийн засгийн ухагдахуун бөгөөд үүний эд эс нь нийгмийн субъектүүдийн хоорондын сүлжилдсэн харилцаа холбоо байдаг. Ажилчид нь нийгмийн хөгжлийн бодит хүчин болохын хувьд нийгмийн өөрчлөлтийн чиг хандлагад хэрхэн холбогдон хөгжих ёстой талаар хариулт шаардсаар байна.

Холбооны, бүсийн, мужийн, орон нутгийн бүхий л шатны төр засгийн шийдвэрт иргэд нөлөөлж чаддаг эсэх талаар судалгаанд оролцогчдын 92 хувь буюу дийлэнх нь оролцож нөлөөлөх боломж байхгүй хэмээн хариулжээ. Судалгаанд оролцогчид гутранга үзэлтэй байсан уу гэвэл бидний бодож байгаагаар үгүй юм. Ажилчид нийгмийн бүтцийн нэгэн хэсэг болохын хувьд нийгмийн өөрчлөлтийн үйл явц, амьдралын нөхцөл байдалд дасан зохицох асуудал чухал байдаг. “Оросын нийгэмд өрнөж буй улс төрийн байдлыг сонирхдог уу?” гэсэн асуултанд тэдний 66 хувь нь сонирхдог гэж хариулжээ. Тийнхүү ажилчид нийгмийн ч, улс төрийн ч үүргээ хэрэгжүүлж эхэлсэн. Судалгаанд оролцогчдын 80 хувь нь сонгуульд оролцсоныг харвал тэд иргэний үүргээ биелүүлж байна. Үнэндээ, сонгуулийн үр дүн тэдний хувьд нэг л байдаг,

тухайлбал улс орныг удирдахад ардчилал байхгүй байна хэмээн ажилчдын 78,9 хувь үзэж байна.

Эдгээр байдал нь ажилчдын нийгэм-сэтгэл зүйн байдалд болон маргаашдаа итгэх итгэлд нөлөөлж, өнөөдрөөсөө хүртэл айж байна. Тэдний 83,8 хувь нь ирээдүйдээ сэтгэл зовниж байгаагаа илэрхийлжээ. Өнөөдөр тэд эдийн засгийн хямрал, гэмт хэргээс эмээхдээ юуны өмнө 53,2 хувь нь үнийн болон дулаан цахилгааны зардлын өсөлт, 45,3 хувь нь материаллаг хангамж, 40 хувь нь улс орны эдийн засгийн байдал, 30,6 хувь нь ажилгүйдэл зэрэгт сэтгэл зовниж байна.

Улс орны нийгэм-сэтгэл зүйн нөхцөл байдлыг судалгаанд оролцогсдоор дүгнүүлэхдээ дараах харилцааны хэлбэрүүдийг сонирхсон юм. Үүнд:

1. Залуу болон ахмад үеийнхний хоорондын харилцаа
2. Баячууд болон ядуучуудын хоорондын харилцаа
3. Төрийн албаныхан болон хүн амын хоорондын харилцаа
4. Ажил олгогч болон хөлсний хөдөлмөр эрхлэгчдийн хоорондын харилцаа
5. Олон үндэстнүүдийн хоорондын харилцаа

Судалгаанд оролцогсдын 59,6 хувь нь баячууд болон ядуучуудын хоорондын харилцааг (2) муу гэж үнэлсэн нь хамгийн өндөр хувьтай бол 53,6 хувь нь төрийн албаныхан болон хүн амын хоорондын харилцааг (3) тааруу, 33,2 хувь нь ажил олгогч болон хөлсний хөдөлмөр эрхлэгчдийн хоорондын харилцааг (4) сөргөөр, 29,1 хувь нь олон үндэстнүүдийн хоорондын харилцааг (5) муу хэмээн үнэлжээ. Иргэний нийгмийн бүтэц бүрэлдэн тогтоогүй болон нийгмийн өөрчлөлтийн идэвхтэй субъектүүд байхгүй үед төр засгийн байгууллагад итгэх итгэл сул байгаа бөгөөд баянчууд ба ядуучууд, бизнес эрхлэгч ба хөлсний хөдөлмөр эрхлэгчийн ялгаа тогтвортой хэвээр байна.

Ажилчдын хөдөлмөрийн мобил хөдөлгөөний асуудал анхаарал татсан асуудал юм. Энэхүү үйл явц нь амьдралын объектив болон субъектив хүчин зүйлүүд бий болсноор улам идэвхижсэн. Өнөөгийн Оросын хөдөлмөрийн зах зээл нь үүсэл төлөвшлийн эхэн үедээ байгаа учраас энэ үед байдаг бүхий л онцлогуудыг өөртөө тээж байна. Юуны өмнө, нэг талаас хөдөлмөрлөх хүчний эрэлт хэрэгцээ тааруу байгаа, нөгөө талаас зах зээлийн харилцаа нь нийгмийн бүхий л давхрааныхны идэвхийг өрнүүлж байна. Нийгмийн өөрчлөлтийн үед хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн идэвхжиж, хөдөлмөрлөх хүчний үндсэн урсгал гадаад улс орнууд руу чиглэсэн бол бүс мужийн хөдөлмөр эрхлэлтийн онцлогтой холбоотойгоор харилцан адилгүй хөдөлмөрийн зах зээл оршдог улс орон доторх шилжих хөдөлгөөн их байна. Хөдөлмөрлөх хүчний урсгалын идэвхжил болон өөрчлөлтөнд олон хүчин зүйлс нөлөөлсөн. Энэ нь нийгэм-эдийн засгийн болон улс төрийн цогц зөрчлийн үр дүн юм. Энэхүү зөрчлийн эмпирик илрэл нь дараах асуултуудын хариултаас харагдана. Үүнд: “Та улс орны эдийн засгийн бодлогыг юу гэж бодож байна вэ?”, “Та улс орны нийгмийн бодлогыг юу гэж бодож байна вэ?”, “Та улс орны улс төрийн нөхцөл байдлыг юу гэж бодож байна вэ?” Эхний асуултанд 56 хувь, хоёрдах асуултанд 58,5 хувь, гуравдах асуултанд 40,5 хувь нь сөрөг хариулт өгчээ.

Оросоос бусад улс орон руу цагаачлахыг судалгаанд оролцогсдын бараг дөрөвний нэг нь хүсч байгаа боловч тэдний 15 хувь нь ингэхийн тулд ямарч боломж байхгүй байна гэжээ. Цагаачлалын сэдлийг авч үзэхдээ хэд хэдэн бүлэгт ангиллаа. Үүнд: а.материаллаг (хангалттай цалин хөлс байхгүй), б.мэргэжлийн (мэргэжлийн чадвараа хэрэгжүүлэх боломжгүй), в.нийгмийн (аюулгүй байх боломж байхгүй, төр засгаас эхлээд гэмт хэргээс айхгүй байх боломжгүй), г.амьдралын хэтийн төлөвлөгөө (ирээдүй тодорхой бус) зэрэг болно. Судалгаанд оролцогсод Орос оронд аюулгүй байж хамгаалагдах боломжгүй гэж 63,4 хувь, ирээдүй бүрхэг гэж 20,4 хувь нь үзжээ. Бусад сэдэл нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой, тухайлбал 17 хувь нь материаллаг шинжтэй, 5 хувь нь мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой байна.

Ийнхүү өнөөгийн ОХУ-д хөдөлмөр эрхэлж хүн амыг төлөөлж чадахуйц бүлэг бодитойгоор бүрэлдэх хандлагатай байна. Энэ нь нэг талаас, улс орны нийгэм-эдийн засаг, улс төрийн төвөгтэй нөхцөл байдлын үр дүн, нөгөө талаас нийгмийн хөгжлийн болон хувь хүний хэрэгцээнд тохирох арга хэрэгслүүдийг шаардаж байна.

Шилжилтийн үеийн Оросын нийгэмд өрнөж буй нийгэм-эдийн засаг, улс төрийн өөрчлөлт нь ажилчдын нөхцөл байдал, түүний өөрчлөлтөнд хэрхэн нөлөөлж байгааг судлах судалгаа шинжилгээний маш чухал талбар болгож байна. Энэ нь ажилчдын бүтэц ялгарлын дотоод механизмыг судлахаас гадна нийгмийн шинэ бүлгийн үүсэл хөгжил, өмнө байсан бүлэг давхрааны өөрчлөлтийг авч үзэх нь ач холбогдолтой юм. Оросын нийгмийн өөрчлөлт нь ажилчдын нөхцөл байдлыг үлэмж өөрчлөхийн зэрэгцээ зах зээлийн харилцаан дах нийгмийн

давхраажлын жам ёсны хүчин зүйлүүд үйл ажиллагаанд орсон. Төрийн өмчийн шинэчлэн зохион байгуулалтын үр дүнд хөдөлмөрийн харилцааны өөрчлөлтийн үр дагаврыг амсаж буй субъект бол хөлсний хөдөлмөр эрхлэгчдийн бүрэлдэхүүнд орж буй ажилчид юм.

Энэхүү өгүүлэлдээ бид өнөөдрийн ОХУ-ын ажилчдын нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлохыг оролдсон бөгөөд бодит амьдрал дээр тэдний нөхцөл байдал ажиллах хүчний эрэлт хэрэгцээ болон нийгмийн орчноос ихээхэн хамаарч, зан үйлийн сэдэл нь ч нийгмийн янз бүрийн хүрээнд өөрчлөгдөж байдаг аж.

Энэхүү шинжилгээний суурь мэдээллийг ХХI зууны хоёрдах арван жилд авсан нь макро эдийн засгийн зохицуулалт дээр суурилсан өөрчлөлтүүдийн сөрөг болон эерэг үр дүнг харж болохуйц цаг үе тохиосон юм. Нийгмийн бүтцийн судалгаанд ахиц гаргахын тулд ажилчдын хувийн онцлог шинж, тогтсон хандлага, харилцаа холбоо, баримжаалал зэрэг асуудлын талаар эмпирик мэдээлэлд нарийвчилсан шинжилгээ зайлшгүй хийх шаардлагатай байна. Бидний судалсан ажилчид нь мэргэшил болон боловсролын хувьд харьцангуй өндөр давхраа байсан юм. Ажилчдын хөдөлмөрийн үнэ цэнэ, хариуцлага нь цалин хөлснөөс ихээхэн хамаарч байсан бөгөөд цалин хөлс нь тийм ч өндөр бус байгааг тэмдэглэх хэрэгтэй. Хөдөлмөр эрхэлж буй хүн амын доторх ажилчдын бүлэг нь ажиллаж, амьдарч буй нийгмийн шинэ орчиндоо дасан зохицох шаардлагатай болсон.

Нийгмийн томоохон нийтлэг болох ажилчдын давхрааг судалсан эмпирик судалгааны дүнгээр тэд өнөөдөр болон маргаашийн өдөртөө итгэх итгэл нь доогуур байгаа бөгөөд иргэний эрх, эрх чөлөө, итгэл найдвараа мэдэрч чадахгүй байна.

Улс орны нийгэм-эдийн засаг болон улс төрийн хөгжлийн талаар ажилчид үлэмж сөргөөр үнэлж байгаа нь нийгмийн өөрчлөлтийг зохистойгоор хийх, ялангуяа хүн амын бүхий л давхрааныхны аюулгүй байдлыг хангах, иргэдийн ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Ийм нөхцөлийг хангаж чадсанаар нийгмийн бүлгүүд хийгээд иргэдийн хувийн нөөц боломж, дасан зохицох чадвар бүрэн хэрэгжиж чадах юм.

#### Ном зүй

1. Россия в цифрах. 2011 г. Федеральная служба государственной статистики (Росстат). Краткий статистический сборник, М. 2011 С. 95
2. Там же, С. 98
3. См., например, Гордон Л.А., Назимова А.К. Рабочий класс и научно-технический прогресс. М.,1986.
4. Рабочий класс СССР. Тенденции и перспективы социально-экономического развития. М., 1985. Аитов Н.А. Советский рабочий М.,1981. Подъем культурно - технического уровня рабочего класса М.,1961.
5. См. Солидаризация в рабочей среде. Социальное и индивидуальное под. ред. В. А. Ядова. М., Из-во ИС РАН, 1988, с. 5-6
6. Россия в цифрах, с. 97-98
7. Там же, с.125